

НИЙТЛЭЛИЙН ХЭЛЭХҮЙН ОНОЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

С.Мөөмөө¹

Хэл шинжлэлийн ухааны нэгэн салбар болох нийтлэлийн хэлэхүй манайд тун бага судлагдсан юм. Урнаар өгүүлэх, тайзны хэлэх хоёр онол, арга зүйн хувьд ялгаатай. Эртний Герегт “Аггон” хэмээх илтгэх урлагийн уралдаан зохиож мэргэн цэцэн үг, саруул цэлмэг ухаанаараа өрсөлддөг байжээ. Сократ, Платон, Аристотель, Перикл, Демосфон зэрэг алдар цуугаараа гайхагдсан олон суут илтгэгчид гарсан билээ.

Эртний Ромчууд үг ярианы бурхан Пейтоог эрхэмлэн дээдэлж, Марк Тумий Цицерон, Гай Юлий Цезарь зэрэг алдартай илтгэгчдийг төрүүлсэн аж. Европод гайхамшигт илтгэгч, хутагт Август, Авкини фома нар ихээхэн алдаршив.

Английн Бэкон, Италийн Бруно, Голландын Спиноза, Францын Вольтер, Герман нь Кант, орост илтгэх урлагийг шинжлэх ухаан болгосон хүн бол М.В.Ломоносов яахын ч аргагүй мөн.

Тэрээр “Уран үгсийн гарын авлага”, “Үгсийн өврийн толь бичиг” зэрэг бүтээлдээ уран хэлэхийн ур эрдмийг улам шат ахиулжээ. Орост Никита Сергеевич Хрущевыг уран илтгэгч байсан гэдэг

Америкийн илтгэх урлагт Аврам Линкольн, Жон Кеннеди, Жорж Вашингтон, Бенжамин франклин, Тедди Рузвельт, Рональд Рейгэн, Билл Клинтон нарын шилдэг, үе үеийн алдартай илтгэгчдээс бүрэлдэн, нэг үгээр хэлбэл; аугаа Америк орны удирдагчид ард түмнийхээ дунд тухайн цаг үеийн шилдэг уран илтгэгчээр тодордог байх гэж хэлж болно.

Хожуу шинэ үеийн илтгэх урлагт дэлхийн илтгэх урлагийн шинэ алтан үеийг бий болгосон гавьяатай. Дуу хоолой гэдэг бол илтгэгчид байгаа хөгжмийн зэмсэг юм. Дээр нь мэдээж дуу хоолойныхоо хөг аялга, өнгийг тодруулдаг ажээ.

Дуу хоолойн өнгө, чанга, сул (темп), зогсоц завсарлага, амьсгаа авах, дуудлага, өгсөх, уруудах өнгөөр утгыг тодотгоход шийдвэрлэх үүрэгтэй. Нийтлэлийн хэлэхүйд дараах хоёр нөхцөл элемент (махбод) чухал.

1. Олон хүн цугларсан танхим
2. Албан ёсны байдал (жүжиг, концерт, лекц, хурал, хичээл, шүүх хурал)

Ердийн хэлэхүй нь аман харилцаа, хэдэн тооны сонсогчидтой. Нөгөөтөх нь өдөр тутмын байдал юм. Нийтлэлийн хэлэхүйг хийсвэр, бодит хоёр аргаар судалж болно. Ялангуяа, сүүлийн үед интонация (аялга)-д хийсвэр, бодит арга өргөн дэлгэр хэрэглэж байна. Жишээлбэл; оросын нэрт академич А.М.Пешковский “Русский синтаксис в научном освещении”. (Оросын өгүүлбэр зүйд шинжлэх ухааны гэрэл тусгахад)

¹ Доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Бүтээлдээ: орос хэлний аялгын тухай бичихдээ “Внимательно” гэдэг үгийг 22 хөг аялгаар хэлж болно” гэжээ. Тус зохиолд Г.Простакова авгай бол оросын зохиолч Фонвизиний “Ухаантын зовлон” гэдэг зохиолд гардаг хүн. Хөлсний тэрэг л байвал газар зүйгээр юу хийдэг юм бэ? Бас түүний Недросль (шолой хүү) зохиолд “Я не хочу учиться, а хочу жениться” гэж хэлдэг. Энд “шолой” гэдэг үгийг хүмүүст хүргэхээр миний бие эш татав.

Монгол улсын хөдөлмөрийн баатар ардын жүжигчин агсан Гомбосүрэн гуай “Сайн” гэдэг үгийг 100 аялгаар хэлж болно” гэжээ.

1. А.М.Пешковский. Москва. 1956.

Бодит арга буюу туршин судлах авиан зүйн арга гарах хүртэл дэлхийн бүх эрдэмтэд аялгыг хийсвэр аргаар судалж байлаа.

Орчин үед инструментальная фонетика, экспериментальная фонетика (Турших арга) гарснаар техникийн тусламжтайгаар судлах болжээ.

Фланаган, Фант, Шерба, Яссем, Сугото, (Японы эмэгтэйчүүдийн их сургууль), Л.К.Цеплитес (Латвийн ШУА-ийн хэл, зохиолын хүрээлэнгийн авиан зүйн лаборатори) АНУ-ийн массачусетийн дээд сургуульд (Ноберт Винер зэрэг эрдэмтэн кибернетикийн шинжлэх ухааныг үүсгэсэн) бодит аргын судалгаа их өндөрт сүндэрлэж байна. Үнэхээр хэлний амин сүнс нь аялга мөн.

Тухайлбал: Туршилт арга нь мяралзал бичлэг (осциллограмм), солонгон бичлэг (спектрограмм), кино зураг (кимосъемка, анфас, профиль), тагнайн бичлэг (палатограмм), гэрлээр бичих (рентгенограмм), герцээр бичих (фурмантная характеристика)

Rose Nash “Turkish intonasion” хэмээх зохиолоо туршин судлах аргаар бичсэн. Энэ аман хэлэхүйн соёлын үндэс, аязын хэл шинжлэлийн үүрэг, их өгүүлбэр, хэлцийн гэх зэргээр авч судалсан байна.

Үүнээс ажиглахад сонсол зүй, өгүүлүүр зүйг багажаар судалж байгаа юм.

Монгол улсад гэхэд уран илтгэгч, уран нийтлэл, уран сайхан ярьдгийн хувьд миний бодлоор Ц.Дамдинсүрэн гуай, Б.Ширэндэв гуай, Д.Цэвэгмид гуай, Л.Цэнд (Төв хороо) Д.Төмөр-Очир гуай, С.Жалан-Аажав гуай, Ч.Лодойдамба, Д.Удвал гуай, Төрийн шагналт, эрдэмтэн Ц.Цэнд, Жанцанноров, Ц.Элбэгдорж нарыг нэрлэж болмоор санагдах юм. МУИС-ийн Цэгмидийн Сүхбаатар, удирдлагын академийн багш Пүрэвийн Увш нарын бичсэн “Илтгэх урлаг” суралцах бичиг зохиолыг эргүүлж, үзэхэд, урьд, одоогийн олон эрдэмтний нэр, хэлсэн үгээс эш татсан байна. Харамсалтай нь илтгэх урлагийн амин сүнс болсон аялга гэдэг үгийг хэрэглээгүй байна.

Уг нь монголын алдарт эрдэмтэн Лхаарамба Агваандандарын зохиосон “Үсгийн номлол мэргэдийн амны чимгээс” хэмээх зохиолоос эшилсэн бол зүгээр байхсан.

Агваандандар: “Олныг сонссон боловч номлохуй дур эс мэргэжвээс эмээр үгээгүү мэргэн эмч мэт, тэмцэхүй дур мэргэн боловч зохиох ёсонд эс мэргэжвээс зуун хэл хувилгаж өгүүлэх боловч хэлгий мөн. Зохиол сайн боловч гараар бичиж, эс найруулах бөгөөс чадал хүч ихтэй баатар ану гар мухар адил. Зохиох үгс сумдаг ямарчлан эс болсон бөгөөд мэргэд бэр машид голох тун сэрэмжлэн үйлд. Үсэг ариун боловч зохист аялгуу эс төгсвөөс үзэсгэлэнт эхнэр нүцгэн гүйх мэт. Ёгт нэр, шинэ хуучин дохио бэр чимэгдэхгүй бөгөөс балгадын үгс хольсоны тул мэргэд дүр орхигдох ану, зохистой болмуй. Тийм тул бага ухааны орон нугудыг судлах нь үнэгүй хэмээн орхилгүй бүгдийг нягт бэр судалсан бөгөөс сая мэргэдийн суудлын эхийг олмуй” гэжээ.

Монголч эрдэмтдийн тавдугаар их хуралд миний бие илтгэл тавихад учир мэдэх ухаант эрдэмтэн Ц.Хасбаатар хэлэхдээ бид бүхэнд ихээхэн чухал санал дэвшүүлсэн, чухал сонирхолтой илтгэл хэмээн сайшааж байсныг энд тэмдэглэхийг хүсэж байна.

Ер нь найруулга зүйчид аялгатай энэ асуудлыг огт холбон үзэхгүй нам гүм өнгөрдөг байна.

Зарим эрдэмтэн уран илтгэгч, тайзны урлагтай холбох саналтай байгааг миний бие хуваалцмааргүй байна. Жишээлбэл: Манай уран уншигч Равдан Жагдал нарыг уран илтгэгч гэх үү? уран уншигч гэх үү? Эдгээр хүмүүс Д.Пүрэвдорж, Б.Явуухулан нарын зарим сайн найраглалаас уран сайхан уншдагийг бид мэдэх билээ. ("Сэгс цагаан богд", "Тэхийн зогсоол" гэх зэрэг)

1. 1987 он. Монголч эрдэмтдийн V их хуралд миний тавьсан илтгэл.

Уран илтгэгч, уран уншигч хоёр ялгаатай гэж байгаа миний саналыг дэмжих болов уу гэж итгэж байна. Дээрх хоёр уран уншигч хоёулаа соёлын гавьяат зүтгэлтэн болсон юм.

Нийтлэлийн хэлэхүйг Нэгд: уран сайхны буюу тайзны хэлэхүй (энд уран уншлага багтах болов уу) Хоёрдугаарт: шинжлэх ухааны хэв маяг (лектор, багш нар, хуульчид) Гуравдугаарт: Нийтлэлийн хэлэхүй, хэв маяг (ухуулга, сурталчилгаа) Дөрөвдүгээрт: Мэдээллийн хэв маяг (нэвтрүүлэгч, хөтөлбөр унших)

Нийтлэлийн хэлэхүйн онол, хэрэглээнд урлаг тайзны уран илтгэгчийн хэлэхүйг ялгаж үзэх нь зүйтэй юм. Бодоход уран илтгэх чадвар нь жүжигчид, уран уншигч, нэвтрүүлэгч, багш нарынхаас арай өөр байх учиртай.

Бидний бодлоор хөг аялга (интонация) бол хэлний авианы хэлэхийн агуулгыг илэрхийлэх маш чухал хэрэглүүр мөн. Аялгын бүрэлдэхүүн болох зогсоц (пауза), хөг (тон), аяз (мелодия), тембр (өнгө) хурд (темп), өргөлт ударение (эмфатическое, словесное, динамическое, логическое, музыкальное, өнө (длительность) (урт, богино) хүчлэл (интенсивность) үндсэн хөг (основной тон) гэх мэт

Ер нь хүний хэлэх үйл ажиллагаа нь ерөнхийдөө өгсөх, тэгш, уруудах байдалтай юм. Туршин судлах авиан зүйчид интонома (аялгын нэгж) хэмээх нэр томъёо өргөн хэрэглэх болжээ. Энэ нь фонем судлалын нэгж нь фонем, үг зүйн нэгж нь морфем (дагавар), өгүүлбэр зүйн нэгж нь (синтагма), үгсийн сангийн нэгж нь лексем (үг) утга зүйн нэгж нь сема гэдэгтэй адил ажээ. Мэдэгдлийн утгыг илэрхийлэх нь интанемийн үндсэн үүрэг юм. Бидний бодлоор аялгын сонсолзүй, өгүүлүүр зүйн нэр томъёог ялгаж үзэх нь зүйн хэрэг. Энэ нь шугамын болон авианы дээрээс наалдан гарч ирдэг өнгө, хүчлэл, үндсэн хөгийн давтамж, өнө, (урт, богинын хугацаа) солонгон бичлэгийн дохионы өөрчлөлтийг ялгаж сурах хэрэгтэй юм.

Аялгын зогсоцын харьцангуй өнийг авиа, үе, үг, синтагма, өгүүлбэр, мэдэгдлийн төвшинд хэмжин гаргаж авах болжээ.

Авиан зүй, нийтлэлийн онолын ном, зохиолд зогсоцын янз бүрийн хэв маяг, үүргийг тогтоож байна. Бичвэрт зогсоцыг цэг цэглэлийн дүрмээр тодорхойлно. Бид зогсоцын үүргийг цухас дурдахдаа аялгын хүчлэлийн үүрэг, олон янзын өргөлтийн үүрэг, үндсэн хөгийн давтамжийн үүрэг, хурдын үүрэг, өгүүлбэрийн үүрэг утга зүйн үүрэг, найруулга зүйн үүрэг гэх мэтээр цаашид урган гарах аялгын цогц ойлголт байдгийг нарийвчлан судлах шаардлагатай болж байна.

Хэлшинжлэлийн онолд орчин үе, ирээдүйд нийтлэлийн хэлэхүйн уг сурвалжийг судлах асуудал дэвшин гарч ирэв.

SUMMARY

In this article, the author discusses the speech of publication in Mongolian by the point of theoretical and practical view. Also, the author cited some examples from Mongolian.